



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН” ІУРСГАЛ УС ХХКІ



Ерөнхий дүгнэлт:

Урсгал-Ус ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан, удирдлага, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт хийж, үр ашиггүй зардлуудыг бууруулснаар ашигтай ажиллах бүрэн боломжтой байна.

Сүхбаатар хотын цэвэр, бохир усны систем



Сүхбаатар сум 2016 он

Тайланг бэлтгэсэн:
ҮАГ-ын харьяа
Сэлэнгэ аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх
Аудитор
Б.Эрдэнэзул

2016 оны 09 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70363036
дугаарын утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

- 1.1. Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- 1.2. Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу?
- 1.3. Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу?

2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?

- 2.1. Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу?
- 2.2 Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?
- 2.3 Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх ?

3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

- 3.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу?
- 3.2 Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу?
- 3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ОХУ	Оросын холбооны улс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт
МНААХҮХ	Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААН	Аж ахуйн нэгж
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УЦУОША	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. 1. Аудит хийсэн үндэслэл

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

1. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

Урсгал-Ус ХХК-ийн 2015, 2016 оны 1-4 сар хүртэлх үйл ажиллагааг хамруулсан болно.

1.3 Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан Урсгал-Ус ХХК-ийн захирал, нягтлан бодогчид, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, компанийн ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, ААНОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Б.Эрдэнэзул 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэв.

1.5 Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн нийтийн аж ахуйн Урсгал-Ус ХХК нь 1931 онд “Нийтийн үйлчилгээний товчоо, хот тохижилт” нэртэйгээр байгуулагдаж, 1997 онд “Урсгал” улсын үйлдвэрийн газартай нэгдэн Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон зохион байгуулсан бол 2005 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын 78 дугаар тогтоолоор ХХК болгон өөрчилсөн байна.

Тус компани нь Захиргаа аж ахуй, борлуулалтын, Цэвэр ус хангамжийн, Ариутгах татуургын, Нийтлэг үйлчилгээний, Авто гражийн зэрэг 5 албатайгаар, 100 орчим орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Бүлэг 1

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.

Урсгал-Ус ХХК нь зөвхөн санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж байгаа бөгөөд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулаагүй байна.

1.1 Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлүүдийн зарим нь улсын бүртгэлийн гэрчилгээ болон бодит байдалтай нийцээгүй байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 10 сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1-р хавсралтаар “Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суман дахь Урсгал-Ус ХХК-ийн дүрэм”-ийг баталжээ. Тус дүрэмд үйл ажиллагааны 5 чиглэлийг хэрэгжүүлэхээр баталснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 3 чиглэлийг хэрэгжүүлж, туслах үйл ажиллагааны 2 чиглэлийг хэрэгжүүлээгүй байна.

Үндсэн үйл ажиллагааны дараах 3 чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын албан газар, аж ахуйн нэгж, хүн амыг цэвэр усаар хангах, аж ахуйн нэгж байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж цэвэрлэх,
2. Ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг график төлөвлөгөөтэй хийж, хэрэглэгчдээс гарсан санал хүсэлтийг цаг тухайд нь барагдуулж ажиллах,
3. Нийт ажиллагсадын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг хангаж, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж, хамтын гэрээ байгуулан дүгнэж байх.

Тус компани нь Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12-р зүйл¹д заасан үйл ажиллагаа явуулах 00146 тоот Тусгай зөвшөөрлийг

¹ 12.2.1 хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.3 цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.4 цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.5 орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.7 бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.8 бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.9 бохир ус татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.10 бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.11 ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ; 12.2.12 хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.3 зөөврийн ус хангамжийн үйлчилгээ; 12.2.14 бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс 2015 онд 3 жилийн хугацаагаар сунгуулсан байна.

Туслах үйл ажиллагааны дараах 2 чиглэлийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. Дүрэмд гадаад, дотоод худалдаа эрхэлж, иргэдэд шуурхай чирэгдэлгүй үйлчилж ажиллах гэсэн үйл ажиллагааны чиглэлийг баталж өгсөн ч байгуулагдсан цагаас өнөөг хүртэл энэ төрлийн үйл ажиллагаа огт явуулаагүй байна.
2. Мөн иргэдэд халуун ус, хорооллын Ка ТВ, жолооны В ангилалын курс, дулаан гражаар үйлчилж гадаад дотоод худалдаа эрхэлж, иргэдийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн шаардлагад нийцүүлэн ажиллах гэсэн ажлуудын заримыг явуулж байгаад зогсоосон бол зарим үйл ажиллагааг огт явуулаагүй байна. Тухайлбал халуун ус, граж түрээслүүлэх үйл ажиллагаа явуулж байсан барилгыг нийгмийн даатгалын өрөнд өгөх, ашиг орлого буурсан шалтгаанаар 2013 оноос зогсоожээ. Харин Кабелийн ТВ-ийн үйлчилгээ огт явуулаагүй, жолооны курсыг 2005 оноос хойш ажиллуулаагүй байна.

Урсгал-Ус ХХК нь улсын бүртгэлд 2005 оны 1314001002 дугаарт бүртгүүлэн, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр усан хангамж ариутгах татуурга, туслах үйл ажиллагааны чиглэлээр усны хайгуул судалгаа, уст цэгийн өрөмдлөгийн ажил, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга, халуун ус, сауны үйл ажиллагаа явуулахаар гэрчилгээ авчээ.

Сүхбаатар сумын ундны усны нөөцийг анх тооцоолсон ТЭЗҮ-ээс 4 дахин бага хэмжээгээр ашиглаж байна.

Сэлэнгэ аймгийн төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн усны нөөц нь Орхон голын эргээс 3 км-т орших газрын доорх цэнгэг ус байдаг байна.

Сүхбаатар сумын газрын доорх усны нөөцийг 1984 онд БНМАУ-ын “Геологийн төв экспедици”-ээс 9.2 мян.м3/хоногоор тооцож тогтоожээ.

1988 онд ОХУ-ын “Гипрокоммунводоканал” институтээс Сүхбаатар сумын усны нөөц, цэвэр, бохир усны шугам, бохир ус цэвэрлэх байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, цэвэр усны нөөцийг 8.7 мян.м3/хоногоор тооцсон байна. Тухайн үедээ усны нөөцийг 2010 онд буюу 22 жилийн дараа 14.2 мян.м3/хоног хүртэлх усыг ашиглаж болохоор тооцож байжээ.

Гэвч сүүлийн 5 жилийн байдлаар хамгийн ихдээ хоногт дунджаар 2.1 мян.м3/хоног ус олборлож байгаа бөгөөд энэ нь анх тооцоолсон ТЭЗҮ-ээс 4 дахин бага юм.

Үүнээс бусдаар Сүхбаатар сумын цэвэр усны нөөцийн талаар судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна.

Сүхбаатар сум дахь төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоох, бүс тогтоогоогүй объектуудад хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох шаардлагатай байна.

Сүхбаатар сумын усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 1986 онд аймгийн Ардын депутатын хурлаар баталж байсан бөгөөд дахин шинэчлэлт хийгдээгүй, шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Аудитын явцад Урсгал-Ус ХХК-ийн ус хангамжийн эх үүсвэр, ариутгах татуургын барилга байгууламжуудтай биечлэн танилцахад зарим шугам хоолой, ус түгээх барилга байгууламж, худгуудад хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, айл өрхүүд хашаагаа тулгаж барьсан, хайс хашаа, тэмдэг тэмдэглэгээ хийгдээгүй зэрэг байдал ажиглагдаж байлаа. Тухайлбал:

- Салхитын аманд байрлах 1400 м.куб усан сангийн ойр орчим айл өрхүүд байрласан,
- Гурвалжингийн тойрогт байрлах цэвэрлэх байгууламжийн барилга айлын хашаатай нийлсэн, хаяг, хашаа, тэмдэгжүүлэлт хийгдээгүй,
- Салхитын ам дах төв шугамын тросс дагуу айл өрхүүд байрласан,
- Сүхбаатар сумын айл өрхүүдэд ус түгээж байгаа 27 худагт хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоогүй, хайс хашаа бариагүй байна.

Энэ нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17-р зүйл заалтуудыг² зөрчиж байна.



1-р цэвэрлэх байгууламжийн барилгатай нийлүүлж айлын хашаа байшин баригдсан байдал



1400 м.куб усан сангийн хашаатай нийлж айл өрх байрласан байдал

² 17.4.1.хот, суурины төвлөрсөн бүс ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд;

17.4.2.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг Усны тухай хуулийн 31.3-т заасны дагуу;

17.6.Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно.

17.8.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 31.2.1-д зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 17.8.4.газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох.

1.2 Урсгал-Ус ХХК нь зөвхөн санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж байгаа бөгөөд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулдаггүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;” эрхтэй гэж заажээ.

Үүний дагуу Сэлэнгэ аймгийн ИТХ-аас 2 жилд нэг удаа Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны тухай хэлэлцэн ТУЗ, гүйцэтгэх захирал нарт үйл ажиллагааны менежментээ сайжруулан зардлаа хэмнэж, өр авлагаа бууруулах талаар идэвхи санаачлагатай ажиллах, иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанар хүртээмжийг дээшлүүлэн хэрэглэгчийн тоог өсгөх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх, цэвэр усны шугамд холбогдсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад усны тоолуур суурилуулж бодит хэрэглээг тооцох, усны алдагдлыг бууруулах зэрэг үүрэг даалгавруудыг өгчээ. Гэвч үүрэг даалгаврын хэрэгжилт болон шаардлагатай асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн, шийдвэрлэх асуудлуудын гарцын талаар авч хэлэлцээгүй байна.

Урсгал-Ус ХХК-ийн ТУЗ-ийг аймгийн ИТХ-ын 2015 оны 49 дугаар тогтоолоор дарга, 4 гишүүнтэйгээр баталжээ.

ТУЗ-ийн хурлыг Компанийн дүрэмд³ жилд 2-оос доошгүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 130 дугаар тогтоолоор баталсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д⁴ улирал бүр хуралдуулна гэжээ.

Урсгал-Ус ХХК-ийн ТУЗ нь 2015 онд 1 удаа хуралдаж 2014 оны санхүүгийн тайлан баланс, 2015 оны төсөв батлах, үндсэн хөрөнгө актлах, цалин тогтоох, хөрөнгө оруулалт батлах зэрэг асуудлыг хэлэлцэж 5 тогтоол гаргасан бөгөөд 2016 оны 1-р улирлын байдлаар ТУЗ хуралдаагүй байна.

Хэдийгээр ТУЗ-ийн дарга, нарийн бичиг, 4 гишүүний цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд жилд 13,453.2 мянган төгрөг зарцуулж байгаа ч компанийн дүрэм болон журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал:

- Үйл ажиллагааны дүрмийн 6.1.2, 6.1.3-т заасан санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэж, төсөв баталж байгаа ч үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлоогүй,
- Удирдах зөвлөлийн хурлыг жилд 1 удаа хийсэн,
- ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, хийсэн ажлын тайлан гаргаагүй,
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс өгсөн үүрэг даалгаврын мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

³ Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суман дахь Урсгал ХХК-ийн дүрэмийн 6.1.5 Удирдах зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй хийнэ.

⁴ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах нийтлэг журмын 2.2 ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал бүр хуралдуулна. ...

Тус компанийн захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль⁵ болон компанийн дүрэмд⁶ заасны дагуу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө батлуулан мөрдөх ёстой ч зөвхөн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө батлуулан мөрдөж иржээ.

Урсгал-Ус ХХК-ийн 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд нийт 67 ажил хийхээр төлөвлөснөөс 51 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 12 ажлыг дутуу, 4 ажлыг огт хийгээгүй бөгөөд нийт төлөвлөсөн ажлын хэрэгжилт 90.2 хувьтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хийх ажлын тоо	Үүнээс		Хэрэгжээгүй ажлын шалтгаан
			Дутуу хэрэгжсэн	Огт хэрэгжээгүй	
1	Усан хангамж	16	5	1	Хлоржуулах өрөөнд засвар хийх ажлыг төлөвлөсөн боловч дотор нь байрлуулах тоног төхөөрөмжийг авч чадаагүй тул хийгээгүй.
2	Ариутгах татуурга	11	1	1	Цэвэрлэх байгуумжийн хуучин тунгаагуурыг засварлаж бэлэн байдалд оруулах ажлыг төлөвлөсөн ч үүнийг хийх шаардлагагүй гэж үзэн хийгээгүй.
3	Нийтлэг үйлчилгээ	8	2	1	Конторын гадна фасад будах, дотор засвар хийхээр төлөвлөсөн ч хөрөнгө, мөнгөгүй тул хийгээгүй.
4	Авто граж	8	2		
5	Цахилгаан хангамж	6	1		
6	Лаборатори	11		1	Ундны усыг хлоржуулах ажил төлөвлөсөн ч хлоржуулах аппарат авч чадаагүй тул хийгдээгүй. Тус аппарат нь зах зээлд 40.0 сая орчим төгрөгийн үнэтэй байдаг байна.
7	Борлуулалтын алба	7	1		
Нийт дүн		67	12	4	

Цаашид үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөө зэргийг улс, болон орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан боловсруулж, ТУЗ, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

1.3 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж ажиллахгүй байна.

Аудитад хамрагдсан хугацаанд үндсэн үйл ажиллагаатай холбоотой 5, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна.

Бусад байгууллагаас үндсэн ажиллагаатай холбогдолтой 5 удаагийн дотоод хяналт шалгалт хийгдэж, 2 албан шаардлага, 35 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 13 зөвлөмж хэрэгжиж, 7 нь хэрэгжээгүй, 2016 онд хийгдсэн хяналт шалгалтын 15 зөвлөмж хэрэгжих шатандаа явж байна. Тодруулбал:

⁵ 19.1 1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна..., 78-р зүйл Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх 78.2.2 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;

⁶ 7.1 Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

1. Барилга, Хот байгуулалтын яамнаас 2013, 2014 оны байдлаар бохир ус цэвэрлэх байгууламжуудын цэвэршүүлсэн бохир усанд хяналт шинжилгээ хийж, дүнг 2015 онд ирүүлсэн байна. Үүнд тус компанитай холбоотой 1 зөвлөмж өгөгдснийг дутуу хэрэгжүүлжээ.
2. Аймгийн МХГ-аас Ус цаг уур орчны шинжилгээний албанаас ирүүлсэн албан тоотын хүрээнд 2015 оны 6-р сард төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, байгаль орчны, эрүүл ахуй, халдвар хамгааллын, барилгын техникийн хяналтын чиглэлээр нийт 16 төрлийн зөрчлийг арилгуулахаар 18-04-035/106 тоот албан шаардлагыг өгчээ. Үүнээс 9 зөрчлийг арилгаж, 7 зөрчлийг бүрэн арилгаагүй байна. Үүнд:
 - Лагийн ариутгал, халдваргүйтэл хийгдээгүй,
 - Хүн амын хэрэглээний усны чанарыг сайжруулах, халдваргүйжүүлэх, хлоржуулах ажлыг хийгээгүйгээс үлдэгдэл хлор шинжилгээгээр илрээгүй,
 - Зөөврийн усан хангамжтай худгийн доторлогоо шаардлага хангаагүй, будаг нь ховхорч зэврэлт үүссэн, савны үлдэгдлийг юүлэх цоргыг савны ёроол байрлуулаагүй, мэргэжлийн байгууллагаас баталсан журмын дагуу халдваргүйтэл хийж үлдэгдэл хлорыг лабораторийн шинжилгээгээр хянан баталгаажуулаагүй, бүртгэл хөтлөлт хийгдээгүй,
 - Нийт ус түгээх цэгүүдэд хамгаалалтын бүс тогтоогоогүй, орчны эдэлбэр газартаа тохижилт хийгээгүй,
 - Ус түгээх үйлчилгээний цэг дээр ажиллаж байгаа түгээгч нар эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдаагүй,
 - Дотоодын лабораторит шинжилгээ бүрэн хийгдээгүй,
 - Тоног төхөөрөмж шугам хоолойн техникийн баримт бичиг, үзлэг хийсэн тэмдэглэл засварын акт байхгүй байна.
3. 2016 оны 4-р сард аймгийн МХГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтаар тээврийн, байгаль орчны, барилгын техникийн, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр нийт 14 төрлийн зөрчлийг арилгуулахаар 18-03-034/50 тоот албан шаардлагыг хүргүүлжээ. Үүнээс өмнөх шалгалтаар залруулагдаагүй 7 зөрчлийг арилгуулахаар дахин зөвлөмж өгсөн байна.
4. Аймгийн МХГ болон УЦУОША-аас жилд 1-2 удаа ундны усны болон бохир усны чанар нь эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхэд шинжилгээ хийж хянадаг ба бактерлогийн шинжилгээг МХГ-аар, химийн шинжилгээг Ус цаг уур, орчны шинжилгээний албаар тус тус хөндлөнгийн хяналт хийлгэдэг байна.

Аймгийн МХГ-аас 2015 оны 5-р сард Могойтын амны 9, Салхитын амны 18-р худаас бусад 28 худаг, 2 зөөврийн авто машинд 3 үзүүлэлтээр эрүүл зүйн нянгийн /бактерлоги/ сорьцын шинжилгээгээр эх үүсвэрийн 5-р худагт нянгийн тоо байх ёстой хэмжээнээс /100 ш/ 2 дахин их байсан бөгөөд Корпусын 1, 3, 5, 7, 33, Буурын голын 25-р худагт 10-107 ширхэгээр их гарчээ.

УЦУОША-аас 2015, 2016 онд нийт 14 худагт 20 үзүүлэлтээр химийн сорьц шинжилгээ хийхэд Салхитын амны 16, 18, 19, 60 айлын 10, 11-р худгуудад төмөр байх ёстой хэмжээнээс /0.3/ 0.09-0.16 мг/л их хэмжээтэй гарсан байна.

Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналтын стандартын хүрээнд ундны усанд мэдрэхүйн 4, химийн 21, бохирын 46, нянгийн 7, ундны усны цацрагийн 2 төрлийн үзүүлэлтийг хянаж байхаар зааснаас МХГ нянгийн 3-5 төрлийн үзүүлэлтээр, УЦУОША химийн 13 орчим төрлийн үзүүлэлтээр, Урсгал-Ус ХХК-ийн лабораторит мэдрэхүйн, химийн нийт 16-21 төрлийн үзүүлэлтээр тус тус сорьц шинжилгээ хийгдэж байна.

Энэ талаар МХГ-ын байцаагч болон холбогдох мэргэжилтнүүдээс тодруулга авахад стандартын дагуу иж бүрэн шинжилгээ хийхэд зардал их ордог тул бүх үзүүлэлтэд шинжилгээ хийх боломжгүй байдаг бөгөөд усны гол гол үзүүлэлтүүдийг түүвэрлэн шинжилж, хянадаг гэсэн тайлбарыг өглөө.

Урсгал-Ус ХХК нь өөрийн лабораторид усны сорьц шинжилгээ хийж байгаа ч Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS0900:2005 стандартын дагуу магадлан итгэмжлэгдээгүй, шаардлагатай тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан зарим үзүүлэлтийг шинжлэн хянаж чадахгүй байна.

Тухайлбал, усан ванн байхгүйгээс шалтгаалан ахуйн бохирдол, эрдэс бодисын хэмжээг хянадаг гол үзүүлэлтүүд болох нитрат, хуурай үлдэгдэл, исэлдэх чанар зэргийг шинжилж чадахгүй байна.

Мөн хлоржуулалтын халдваргүйжүүлэх аппарат байхгүйгээс сүүлийн 3 жил ариутгал хийгдээгүй байгаа бөгөөд энэ нь ард иргэдийн эрүүл мэндэд эрсдэл үүсэхээс гадна шугам хоолойн ашиглалтын хугацааг богиносгох зэрэг сөрөг үр дагавартай ажээ.

Тус компанийн лаборатори нь 2015 онд нийт 30 ус түгээх худгаас /2-р өргөх станц, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн гүний 2 худга болон гүний эх үүсвэртэй ус түгээх 1, зөөврийн 14, төвлөрсөн 12 худга/ жилд 2-9 удаа сорьц авч хяналт хийсэн бөгөөд нийт давхардсан тоогоор 197 объектод шинжилгээ хийжээ.

2015 онд тус компанийн болон МХГ, УЦУОША-ны сорьцын шинжилгээгээр 48 удаагийн зөрчил илэрснээс 4-р сард 25-р худгийг угааж зөрчлийг арилгасан акт үйлдснээс өөрөөр бусад угаалгыг нотлох акт үйлдээгүй, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлан байхгүй байна. Харин Ерөнхий инженерийн баталсан “Зөөврийн худгийн угаалгын төлөвлөгөө”-ний дагуу ус түгээх, дамжуулах объектуудад жилд 1 удаа угаалга хийж, акт үйлдсэн байна.

Мөн хугацаанд Урсгал-Ус ХХК-ийн 2012-2014 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд аймгийн Татварын хэлтсээс хяналт, шалгалт хийжээ. Хяналт, шалгалтаар төлбөр хураамжийг дутуу хураасан, орлогыг тушаагаагүй, татвар ногдох орлогоо бууруулсан, бусад ААН, байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэж авсан цалин хөдөлмөрийн хөлс, шагнал, тэтгэмж, адилтгах бусад орлогод татвар ногдуулаагүй байсан зэрэг 12,463.9 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлөх төлбөрийн акт тавигдаж, төлбөрийг барагдуулсан байна.

Хэдийгээр дотоод хяналт шалгалтууд хийгдэж байгаа ч хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаагүй, өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан гаргаагүй байна.

Цаашид хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой тайлан гаргаж холбогдох албан тушаалтнуудад тайлагнаж байх шаардлагатай бөгөөд энэ нь дотоод хяналт, шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, үйл ажиллагаагаа сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Бүлэг 2

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.

Урсгал-Ус ХХК нь үр ашигтай ажиллах бүрэн боломжтой байна.

Оршил

Урсгал-Ус ХХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 02 дугаар тогтоолоор тайлант оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан бөгөөд 1,387,821.3 мянган төгрөгийн орлого олж, 1,341,242.7 мянган төгрөгийн зарлага гарган, 41,920.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан ч орлого 4.7 хувиар тасарч, зарлага 2.2 хувиар хэтэрсэн бөгөөд 47,873.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.

Мян.төг

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Нийт орлого	1,387,821.0	1,322,414.5	-65,406.5
	Үүнээс: Усан хангамж	1,349,021.0	1,322,414.5	-26,606.5
	Халуун ус	30,100.0	0.00	-30,100.0
	Нийтлэг үйлчилгээ	8,700.0	0.00	-8,700.0
2	Нийт зардал	1,341,242.0	1,370,288.1	29,046.1
	Үүнээс: Усан хангамж	966,112.0	929,079.0	-37,033.0
	Халуун ус	83,799.0	97,888.0	14,089.0
	Нийтлэг үйлчилгээ	105,123.0	150,975.2	45,852.2
	Удирдлагын зардал	186,208.0	192,345.9	6,137.9
3	Үйл ажиллагааны ашиг	46,579.0	-47,873.6	-94,452.6
4	Орлогын татвар	4,658.0	0	-4,658.0
5	Жилийн цэвэр ашиг	41,920.7	-47,873.6	-89,804.6

2.1 Үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж батлуулсан ч төлөвлөсөн үйл ажиллагаагаа явуулаагүй, усны алдагдал тооцоолсноос багассан зэргээс шалтгаалан орлогын төлөвлөгөө 4.7 хувиар тасарсан байна.

2015 онд үйл ажиллагааны орлого 65,406.5 мянган төгрөгөөр тасарсан нь дараах асуудлуудаас голлон шалтгаалжээ. Үүнд:

- Халуун усны болон нийтлэг үйлчилгээнээс /граж, өрөө түрээслүүлэх/ 48,800.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн ч нийтийн халуун усыг ажиллуулаагүй, бусад үйл ажиллагаа явуулаагүй тул уг орлого тасарсан.
- Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын шугамын шинэчлэлтэй холбоотойгоор усны алдагдал багассан тул усан хангамжийн орлого төлөвлөснөөс 109,946.2 мянган төгрөгөөр буурсан байна.

2.2 Урсгал-Ус ХХК нь төсвийг бодитой төлөвлөж батлуулаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаагүй, үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зардал гаргаснаас шалтгаалан төлөвлөсөн зардлыг 2.2 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

2015 онд нийт 1,341,242.7 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн ч 1,370,288.1 мянган төгрөгийн зардал гаргаж батлагдсан зардлын төлөвлөгөөг 29,045.5 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар хэтрүүлжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3.

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны		Хэтрэлт, (хэмнэлт)	
		Төлөвлөгөө мян.төг	Гүйцэтгэл мян.төг	Дүн мян.төг	зөрүү
1	Орлого ДҮН	1,387,821.3	1,322,414.5	(65,406.8)	(4.7)
2	Зарлага ДҮН	1,341,242.7	1,370,288.1	29,045.5	2.2
1	Үүнээс Цалин	461,248.0	499,542.0	38,294.0	8.3
2	НД шимтгэл	106,087.0	114,894.7	8,807.6	8.3
3	ҮХ элэгдэл	195,970.0	245,365.5	49,395.5	25.2
4	Цахилгаан	118,454.4	106,390.9	(12,063.5)	(10.2)
5	Сэлбэг	14,292.4	10,646.0	(3,646.4)	(25.5)
6	Шатахуун	67,838.9	69,257.0	1,418.1	2.1
7	Түлш	44,188.0	47,021.0	2,833.0	6.4
8	Нөхөн олговор, буцалтгүй тусламж	13,000.0	13,539.9	539.9	4.2
9	Материал	214,484.9	82,121.4	(132,363.5)	(61.7)
10	Холбоо	2,850.0	9,688.5	6,838.5	239.9
11	Сургалт	3,000.0	10,000.0	7,000.0	233.3
12	Томилолт	2,400.0	13,492.0	11,092.0	462.2
13	Тээврийн татвар	985.0	698.0	(287.0)	(29.1)
14	Үл ХХ-ийн татвар	3,500.0	450.0	(3,050.0)	(87.1)
15	Газрын төлбөр	2,100.0	395.7	(1,704.3)	(81.2)
16	Ус ашигласны татвар		790.0	790.0	#DIV/0!
17	Урсгал засвар	34,992.0	126,831.7	91,839.7	262.5
18	Программ хангамжийн зардал	1,000.0	1,000.0	-	-
29	Аудитын зардал	3,000.0	3,000.0	-	-
20	Даатгал	4,100.0	4,701.9	601.9	14.7
21	Маркетингийн зардал	1,500.0	1,500.0	-	-
22	Бусад зардал	46,252.0	8,962.0	(37,290.0)	(80.6)
3	Үйл ажиллагааны ашиг (1-2)	46,578.6	(47,873.6)	(94,452.3)	(202.8)
4	Орлогын татвар (3*10%)	4,657.9	-	(4,657.9)	(100.0)
5	Цэвэр ашиг - алдагдал (3-4-5)	41,920.7	(47,873.6)	(89,794.4)	(214.2)

Программ хангамжийн, аудитын, маркетингийн зэрэг 3 төрлийн 5,500.0 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан бол 7 төрлийн зардлыг 10.0-87.0 хувиар хэмнэж, 12 төрлийн зардлыг 2.1-462.2 хувиар хэтрүүлсэн байна. Энэ нь санхүүгийн төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, батлагдсан төсвийг мөрдөж ажиллаагүйг харуулж байна.

Үл хөдлөх хөрөнгийн татварын, газрын төлбөрийн, тээврийн хэрэгслийн татварын, сэлбэгийн, материалын, гэрэл цахилгааны болон бусад зэрэг 7 төрлийн зардлыг 10.0-87.0 хувиар буюу 539.9- 91,839.7 мянган төгрөгөөр хэмнэжээ.

Харин дараах 12 төрлийн зардлыг төлөвлөснөөс 0.02-оос 4.6 дахин хэтрүүлэн зарцуулсан байна. Зардал хэтрүүлсэн шалтгааныг судлахад 7 төрлийн 123,095.4 мянган төгрөгийн зардлыг бодитой төлөвлөөгүйгээс, 3 төрлийн 28,975.6 мянган төгрөгийн зардлыг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулснаас шалтгаалсан бол 3 төрлийн 76,844.7 мянган төгрөгийн зардал зайлшгүй нөхцөл байдлын улмаас хэтэрсэн байна. Тодруулбал:

Зардлыг бодитой төлөвлөөгүйгээс төсөв хэтрүүлсэн:

- Ус ашигласны татварын 790.0 мянган төгрөгийн зардлыг төсөвт тусгаагүй,
- Цалин, НДШ-ийн зардлын 20 хувийн нэмэгдлийг дутуу төлөвлөснөөс цалингийн зардлыг 38,294.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 8,807.6 мянган төгрөгөөр хэтэрсэн,
- Даатгалын зардлыг 601.9 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн,

- Шилэн кабелийн сүлжээнд холбох зардлыг төлөвлөөгүйгээс холбооны зардал 6,838.5 мянган төгрөгөөр хэтэрсэн,
- Тайлант хугацаанд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгасан засварын ажлуудын төсвийг дутуу тусгаснаас урсгал засварын зардлыг 18,367.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 49,395.5 мянган төгрөгөөр буюу 25.2 хувиар дутуу тооцож төлөвлөсөн.

Арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулснаас батлагдсан төсвийг хэтрүүлсэн, хэмнэж болох байсан зардал :

- 2015 онд шатахууны зардалд 67,739.0 мянган төгрөг төлөвлөснөөс усан хангамж, ариутгах, халуун усны үйл ажиллагаанд нь батлагдсан төсвийг 3,924.0 мянган төгрөгөөр хэмнэсэн бол компанийн удирдлага батлагдсан төсвийг 5,141.0 мянган төгрөгөөр хэтрүүлжээ.
- 2015 онд томилолтын зардалд 2,400.0 мянган төгрөг, сургалтын зардалд 3,000.0 мянган төгрөг батлагдсан ч ТУЗ болон Засаг даргаас зөвшөөрөл авалгүйгээр төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал төсөвт батлагдаагүй гадаад томилолтын зардалд 21,234.6 мянган төгрөгийг зарцуулжээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4.

д/д	Албан тушаал, овог нэр	Явсан улсын нэр, зорилго	Гарсан зардлын дүн /мян.төг/	Тайлбар
1	Захирал Э.Эрдэнэбаатар	Солонгос улс, Тэгү, Сөүл хот, МНААҮХ-оос зохион байгуулсан Дэлхийн усны 7-р форум	8,000.0	Албан томилолтын үнэмлэхгүй, удирдамжгүй. Төсөвт батлагдаагүй зардал гаргасан.
2	Ерөнхий инженер Л.Бямбадаш			
3	Захирал Э.Эрдэнэбаатар	АНУ, Лас вегас, Сан франциско хот, МНААҮХ-оос зохион байгуулсан "INTERNATIONAL BUILDERS SHOW" үзэсгэлэн	8,308.0	
4	Борлуулалтын албаны дарга, Эдийн засагч Ч.Эрдэнэтуяа	БНХАУ, Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулсан "IE EXPO-2015" үзэсгэлэн.	4,326.6	Албан томилолтын үнэмлэхтэй. Урсгал-Ус ХХК-д ямар ач холбогдолтой эсэх нь тодорхойгүй.
5	Нийтлэг үйлчилгээний инженер Б.Тэгшжаргал			
6	Гэрээний, цэвэр усан хангамжийн, ариутгах татуургын, цахилгааны 4 инженер	ОХУ, Улан-Удэ, Тодорхойгүй	600.0	Томилолтын үнэмлэх хаалгаагүй, удирдамжгүй.
Нийт дүн			21,234.6	

- Эрх зүйч мэргэжлээр суралцаж байгаа борлуулалтын байцаагч Н.Сувд-Эрдэнийн сургалтын төлбөр 2,100.0 мянган төгрөгийг хууль эрх зүйн үндэслэлгүйгээр, тушаал шийдвэргүйгээр төлсөн,
- Ууланд авирагч спортын тамирчин Урангоод 500.0 мянган төгрөгийн хандив өгсөн зэргээр зориулалт бус зардал гаргасан байна.

Урьдчилан тооцоолох боломжгүй, зайлшгүй нөхцөл байдлын улмаас үүссэн зардал:

- Өмнөх онуудад нүүрс нийлүүлж байсан Редхилл Монголиа ХХК нь нүүрс олборлолтоо зогсоосон тул түлээ, нүүрс зарж байгаа компаниудаас шууд худалдан авалтуудыг хийснээр халаалтын зардал 6.4 хувиар буюу 2,833.0 мянган төгрөгөөр хэтэрсэн,
- Буцалтгүй тусламж, нөхөн олговрын зардлыг урьдчилан бодитой тооцох боломж бага тул батлагдсан төсөв 539.9 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар хэтэрсэн,
- Шугам хоолойнуудын ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөр байгаагаас шалтгаалан гэнэтийн эвдрэл гарч, урсгал засварын зардалд тооцоологдоогүй 73,471.8 мянган төгрөгийн зардал нэмэгдэж гарсан байна.

2016 оны 1-р улирлын байдлаар 449,318.2 мянган төгрөгийн орлого олж, 356,439.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс орлого 6.1 буюу 27,431.0 мянган төгрөгөөр тасарч, зарлага 18.7 хувиар буюу 66,796.8 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Энэ нь Сант суманд хийгдэж байгаа худгийн ажлын зардал, 2 худагт төлөвлөгөөнөөс өмнө урьдчилан засвар хийж байгаа зэрэгтэй холбоотой байна.

Урсгал-Ус ХХК нь үр ашигтай ажиллах бүрэн боломжтой байна.

Урсгал-Ус ХХК-ийн сүүлийн 5 жилийн ашиг, алдагдлыг харахад 3 жилд нь 20,431.1-36,363.1 мянган төгрөгийн ашигтай, 2 жилд нь 22,141.1-47,873.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5.

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ашиг, (алдагдал) /мян.төг/	31,396.4	(22,141.1)	36,363.1	20,431.1	(47,873.6)

2015 онд алдагдал хамгийн өндөр дүнтэй байгаа бөгөөд алдагдалтай ажиллахад дараах нөхцөл байдлууд нөлөөлжээ. Үүнд:

- Цалингийн зардал өмнөх оноос дунджаар 18 хувиар нэмэгдсэн. /ТУЗ-ийн 05 тоот тогтоолоор цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн, ажиллагсадын орон тоо өмнөх оноос 11-ээр нэмэгдсэн/
- Компанийн удирдлагын зардлыг 6,137.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. /санхүүгийн төлөвлөгөөнд 186,208.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан ч 192,345.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан/
- 2015 онд 27 худаг үйл ажиллагаа явуулсан бөгөөд 22,976.1 мянган төгрөгийн орлого олж, 51,696.7 мянган төгрөгийн зардал /шатахуун, цалин,НДШ, түлээ нүүрс, засвар үйлчилгээ г.м/ гаргаснаар 28,720.6 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн.
- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, батлагдаагүй, үр ашиггүй зардал гаргасан.
- Усны алдагдал сүүлийн жилүүдэд буурч байгаа ч 2015 онд хамгийн бага алдагдалтай гэхэд ус үйлдвэрлэлийн 29.8 хувь буюу 63,354.8 мянган төгрөгийн алдагдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6.

Үзүүлэлт	Хэм.нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он
Олборлосон ус	мян.м³	712.7	761.7	720.0	551.0
Борлуулсан ус	мян.м³	324.6	435.7	449.3	387.0
Орлого болоогүй ус (алдагдал)	мян.м³	388.1	326.0	270.7	164.0
Алдагдлын хувь	%	54.5	42.8	37.6	29.8

Урсгал-Ус ХХК нь үр ашигтай ажиллах, үйлдвэрлэлийн ашиг орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байгаа бөгөөд компанийн удирдлагын зүгээс болон аймаг, орон нутгийн удирдлагуудтай хамтран дараах асуудлуудыг судалж, үе шаттайгаар шийдвэрлэж ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

1. Усны алдагдлыг бууруулах зорилгоор тоолуургүй айл өрх, байгууллагыг тоолууржуулах, ашиглалтын хугацаа дууссан, насжилт өндөртэй шугам хоолойнуудыг шинэчлэх тооцоо судалгааг гаргаж, шаардлагатай хөрөнгө нөөцийг улс, орон нутгийн төсөвт суулгаж батлуулах талаар бодитой арга хэмжээ зохион байгуулах.

Өнөөгийн байдлаар Сүхбаатар сумын орон сууцны айл өрхүүдийн 61.1%, үйлдвэрийн газруудын 33.4%, аж ахуйн нэгжүүдийн 24.8%, ус дамжуулах төвүүдийн 20% нь тоолуургүй байна.

Сүхбаатар суманд цэвэр усны 13.7 мянган метр 3,233,900.0 мянган төгрөгийн, бохир усны 20.0 мянган метр урт 3,418,755.2 мянган төгрөгийн өртөг бүхий шугам ашиглагдаж байна. Үүнээс цэнхэр, шар 5 давхарууд, төмөр зам орчмын 1970-1972 онуудад ашиглалтанд орсон цэвэр усны 434,250.0 мянган төгрөгийн, бохир усны 1,434,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий шугам хоолойн ашиглалтын хугацаа дуусаад 4-6 жил болсон байна.

Урсгал-Ус ХХК-д бүртгэлтэй, Сүхбаатар суманд ашиглагдаж байгаа цэвэр, бохир усны шугамын тоо хэмжээ, ашиглалтын талаар нарийвчилсан судалгаа хийгдээгүй, хөрөнгийн бүртгэлд шугам хоолойн тоо хэмжээ тодорхойгүй байна. Цаашид шугам хоолойн тоо хэмжээг нарийвчлан гаргаж, холбогдох тооцоо судалгаанд ашиглах, орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг тодорхой болгох шаардлагатай юм.

2. Эдийн засгийн үр ашгийг бодитой тооцоолсны үндсэн дээр санхүүгийн төлөвлөгөөг батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх.
3. Төсөвт батлагдаагүй зориулалт бусын, онц шаардлага, ач холбогдолгүй гадаад томилолт, сургалтын зардал, хандивын зардал гаргахгүй байх, ТУЗ-ийн зардлыг хийсэн ажлын гүйцэтгэлд үндэслэн олгож байх.
4. Ус хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх талаар шаардлагатай судалгаа, тооцоог гаргаж, айл өрхийг цэвэр, бохир усанд холбох ажлыг аймаг, орон нутгийн удирдлагатай хамтран хэрэгжүүлэх.
5. Урсгал-Ус ХХК-ийн ТЭЗҮ-д хоногт 14.2 мянган м.куб хүртэлх усаар хангах хүчин чадалтай бөгөөд энэ нь 150.0 мянга гаруй хүн амыг усаар хангах боломжтой гэсэн үг юм. Гэвч одоо Сүхбаатар сумын 23.0 мянга орчим буюу 6-7 дахин бага хүн амыг усаар ханган ажиллаж байгаа ч анх байгуулагдсан болон 2 компани нийлүүлсэн бүтэц орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Иймд мэргэжлийн байгууллага, хүмүүсээс бүрдсэн комисс ажиллуулж компанийн бүтэц орон тоо, зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай байна.

2.3 Авлага, өглөгийг барагдуулахаар тодорхой ажил зохион байгуулж байгаа ч төдийлөн үр дүнгүй байна.

Урсгал-Ус ХХК нь 2015 онд нийт 916,380.0 мянган төгрөгийн авлага, 553,100.6 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байна. Тус компани нь нийт авлагын 60 орчим хувийг төвлөрүүлэхэд өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжтой байна.


Авлагын талаар:

Авлагыг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас авах усны авлага нэмэгдэж байгаагаас шалтгаалан 10 орчим хувиар, усны борлуулалтын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор айл өрхөөс авах авлага 56 орчим хувиар тус тус нэмэгдсэн байна.

2015 оны жилийн эцсийн авлагыг насжилтаар нь авч үзэхэд 67.7 хувь нь хугацаандаа төлөгдөөгүй авлага байна.

Хүснэгт 7.

Авлага үүссэн он	Авлагын дүн /мян.төг/
2015	295,634.6
2014	41,771.2
2013	553,526.5
2012	13,852.4
2011 оноос өмнөх	11,595.3
Нийт дүн	916,380.0



Авлагыг бүтцээр нь авч үзэхэд нийт авлагын 78.6 хувийг байгууллагаас авах авлага, 11.4 хувийг айл өрхөөс авах авлага, 1.0 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 6.0 хувийг ажилчдаас авах авлага, 3.0 хувийг НӨАТ, ААНОАТ-ын авлага тус тус эзэлж байна. Үүнээс Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас авах 551,966.7 мянган төгрөгийн усны авлага нь нийт авлагын 60.2 хувийг эзэлж байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8.

д/д	Авлагын дансны төрөл	Дүн мян.төг	Хувь %
1	Байгууллагаас авах авлага	719,844.5	78.6
2	Айл өрхөөс авах авлага	104,658.7	11.4
3	Ажилчдаас авах авлага	54,682.2	6.0
4	хувь хүмүүсээс авах авлага	9,363.9	1.0
5	НӨАТ авлага	24,501.3	2.6
6	Ноогдол ашгийн авлага	3,466.2	0.4
7	Найдваргүй авлагын нөөц	(136.8)	-0.01
	Нийт авлагын дүн	916,380.0	100

Авлагатай холбоотой дараах алдаа, зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- НӨАТ-ын тооцоог хаалгүйгээр 24,501.3 мянган төгрөгийн авлага хий тусгасан,

- Бараа материалыг хүлээн авч зарцуулсан ч баримт бүрдүүлээгүй гэдэг шалтгаанаар материалын орлого, зарлагад тусгаагүй 58,913.2 мянган төгрөгийн бодит бус авлагыг бүртгэлд тусгасан,
- 2005-2013 онд мөнгө шилжүүлснээр үүссэн боловч, эргэж төлөгдөөгүй, бараа материал нийлүүлээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 35,787.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Хүснэгт 9.

д/д	Авлагын дүн /мян.төг/	Авлага үүссэн он	Компанийн нэр
1	1,418.6	2007 оноос өмнө	Жавхлант-Эрдэнэ ХХК. Ямар материал авах нь тодорхойгүй, байгуулсан гэрээ байхгүй
2	6,791.8	2005 оноос өмнө	Орхон Импекс ХХК. Ямар материал авах нь тодорхойгүй, байгуулсан гэрээ байхгүй
3	2,184.2	2012	Ертөнцийн цамхаг ХХК. Ямар материал авах нь тодорхойгүй, байгуулсан гэрээ байхгүй
4	25,392.5	2013	Монхово ХХК. Аймгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хлоржуулалтын тоног төхөөрөмж авах байсан ч зориулалт бусаар зарцуулж, үлдэгдлийг тоног төхөөрөмжийн урьдчилгаанд өгч, өнөөг хүртэл аваагүй.
Дүн	35,787.1		

Үүнээс 2013 онд аймгийн хөрөнгө оруулалтаар хлоржуулах тоног төхөөрөмж бэлтгэхээр батлагдсан 60,000.0 мянган төгрөгийг Монхово ХХК-д шилжүүлэн “Мянганы сорил” сангаас авсан тендерийн ажилд 34,607.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 25,392.5 мянган төгрөгийг өнөөг хүртэл барагдуулаагүй, тоног төхөөрөмжөө нийлүүлээгүй байна.

- Ажиллагсадтай холбоотой, тухай бүр тооцоо нийлж барагдуулах боломжтой 54,682.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байгаа нь орон нутгийн өмч, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, найдваргүй авлага нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Ажиллагсадтай холбогдсон авлагын 98.8 хувь буюу 54,046.2 мянган төгрөгийн авлага нь 8 ажилтан, албан тушаалтантай холбоотой үүссэн байна.

Хүснэгт 10.

д/д	Тооцоо үүсгэсэн ажиллагсадын нэр	Авлагын дүн /мян.төг/	Тайлбар
1000.0 мянган төгрөгөөс дээш төгрөгийн тооцоо үүсгэсэн			
1	Э.Эрдэнэбаатар Гүйцэтгэх захирал	1,110.8	2010 оноос үүсэн. Тендерийн худгийн материал авсан бөгөөд баримт өгч материалын орлого авагдаагүй
2	Л.Бямбадаш Ерөнхий инженер	5,000.3	2012 оноос үүссэн материал нийлүүлнэ, тендерийн худгийн материалын аваад баримт өгч материалын орлого авагдаагүй,
3	Г.Ганбаатар Боловсон хүчин	2,074.0	2015 онд үүсгэсэн, компьютер хэрэгсэл болон поректорийн дэлгэц орлого аваагүй
4	С.Ганцоож Цахилгааны инженер	2,525.6	2012 оноос үүссэн цахилгааны хэрэгсэл аваад баримт өгч материалын орлогод аваагүй,
5	Нэмэхбаатар Механик	6,849.2	2015 онд үүссэн сэлбэг хэрэгсэл аваад баримт өгч орлогод аваагүй,
6	Б.Тэгшжаргал Нийтлэг үйлчилгээний инженер	7,976.2	Сүүлийн жилүүдэд үүссэн нүүрс болон уурын зуухны сэлбэг аваад баримт өгч материалын орлого аваагүй,

7	Д.Ганбаатар ариутгах татуургын инженер	8,032.7	Сүүлийн жилүүдэд үүссэн. Ариутгах татуургатай холбоотой бараа материал аваад баримт өгч орлогод аваагүй,
8	Д.Батчулуун Бараа материалын нярав	20,477.4	Баримт материал дутуу байдлаас шалтгаалан орлого дутуу авагдсан,
Дүн		54,046.2	

- Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулахгүй байгаа бөгөөд 2015 онд 49 байгууллагатай үүссэн 140,775.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
- 2015 онд кассын тайланд 302,622.2 мянган төгрөгийн, 2016 онд 91,649.1 мянган төгрөгийн дараа тайлангийн тооцоо үүсгэн худалдан авалтуудыг хийжээ. Гэвч дараа тайлангийн тооцоог тухай бүр хийж, батлагдсан маягтын дагуу тайлан гаргаагүй, кассын тайланд зохих баримтуудыг хавсаргаж хэвшээгүй байна.

Урт хугацаат өр төлбөрийн талаар

Урсгал-Ус ХХК-ийн санхүүгийн тайланд 88,500.0 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөр тайлагнагдсан бөгөөд бүртгэл нь тодорхойгүй байсан тул тус компанийн ерөнхий нягтлан бодогч болон аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс тодруулга авч, анхан шатны баримт материалтай тулгалт хийлээ.

Тус компани нь санхүүгийн тайлан гаргахдаа авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулдаггүйгээс 2011 оноос эхлэн аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3 удаагийн ажлыг эргэн төлөхөөр тооцож урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэж иржээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аж ахуйн нэгжид мөрдөгдөх дансны заавар зэргийг зөрчихөөс гадна санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд бодит бус мэдээлэл хүргэж байна.

Богино хугацаат өр төлбөрийн талаар

2015 онд богино хугацаат өглөгийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар буюу 52,595.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11.

Мян.төг

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он
Байгууллагад төлөх өглөг	3,111.60	45,910.30	107,131.80
Цалингийн өглөг	894.60		2,114.10
Татварын өглөг	33,919.40	116,542.40	111,714.70
НДШ-ийн өглөг	244,747.00	354,293.70	243,190.50
Бусад өглөг	449.50	449.50	449.50
Нийт дүн	283,122.10	517,195.90	464,600.60

Үүнээс тайлант хугацаанд НДШ-ийн өглөг өмнөх үеэс 111,103.2 мянган төгрөгөөр буурсан бөгөөд гэрэл цахилгааны өглөгийн өсөлттэй холбоотойгоор бусад байгууллагад төлөх өглөг 61,221.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт өглөгийн 52.3 хувийг НДШ-ийн өглөг эзэлж байгаа бөгөөд 24 хувийг татварын өглөг, 23.1 хувийг байгууллагад төлөх өглөг, 0.5 хувийг бусад өглөг эзэлж байна.

Мөн 26 байгууллагад төлөх 66,362.7 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталагаажуулаагүй байна.

Өглөг, авлагыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Урсгал-Ус ХХК нь өр, авлагыг бууруулах арга хэмжээний хүрээнд зөвхөн усны борлуулалтын авлагыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд бусад байгууллага, хувь хүн, ажиллагсдаас авах авлагыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Айл өрхүүдийн хуримтлагдсан өр, авлагыг бууруулахаар Урсгал-Ус ХХК-ийн захирлын 4 удаагийн тушаалаар урамшуулалт сугалаа явуулах, бэлэг өгөх, график гарган айл өрхүүдээр явах зэргээр 4 удаагийн арга хэмжээг зохион байгуулснаас гадна Борлуулалтын албанаас 12 өрхөд мэдэгдэл өгч, Миний Монгол Интертайментийн зар мэдээгээр 2 удаа үгэн зар явуулж, Гаалийн газарт төлбөр төлүүлэх, хамтран ажиллах 5 удаагийн албан бичиг хүргүүлжээ. Мөн Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас усны борлуулалтын 551,966.7 мянган төгрөгийн авлагыг нэхэмжлэн хууль, хяналтын байгууллагад хүргүүлсэн байна.

Үүний дүнд 312,896.4 орчим мянган төгрөгийн авлагыг барагдуулсан нь нийт авлагын 34.1 хувийг эзэлж байна.

Мөн тус компанийн 2015-2016 оны “Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө”-д өр, авлага бууруулах график гарган мөрдөж ажиллах, үйлчилгээний төлбөрөө төлөөгүй аж ахуйн нэгж, айл өрхийг хууль, хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлэх гэсэн 2 ажлыг тусгасан ч гүйцэтгэл нь төдийлөн хангалтгүй байна. Тухайлбал:

- Компанийн захирлын 2015 оны 63 тоот тушаалын дагуу өр, авлага бууруулах график төлөвлөгөө гарган 504.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан.
- Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас сүүлийн жилүүдэд 3 удаагийн нэхэмжлэлээр 766,988.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар сум дундын шүүхэд нэхэмжлэл гаргаж 312,896.4 мянган төгрөгийг барагдуулсан боловч үйлчилгээний төлбөрөө төлөөгүй бусад аж ахуйн нэгж, иргэдийг хууль, хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлээгүй байна.

Цаашид өр авлага бууруулах ажлыг үр дүнтэй болгож, насжилт ихтэй авлагуудыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, бусад албан газар, байгууллагуудтай хамтран ажиллаж айл өрхөөс авах борлуулалтын авлагыг бууруулах, бусад байгууллага, хувь хүн, ажиллагсдаас авах авлагыг нэн тэргүүнд барагдуулах зэргээр тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллах нь зүйтэй юм.

Бүлэг 3

Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу.

Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөөгүй байна.

Оршил

Урсгал-Ус ХХК нь 2015 онд 309,528.8 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч, 281,958.0 мянган төгрөгийн материалыг зарцуулж 535,565.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан бол 37,952.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 12,150.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан байна.

2016 оны 1-р улиралд 121,889.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 186,128.9 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн хөрөнгө худалдан аваагүй байна.

Хүснэгт 12.

Үзүүлэлтүүд	Үндсэн хөрөнгө /мян.төг/		Бараа материал /мян.төг/	
	2015 он	2016 оны эхний 1 улирал	2015 он	2016 оны эхний 1 улирал
Эхний үлдэгдэл	9,765,899.5	9,792,230.6	507,994.8	535,565.6
Нэмэгдсэн	38,482.0	0	309,528.8	121,889.8
Хасагдсан	12,150.9	0	281,958.0	186,128.9
Эцсийн үлдэгдэл	9,792,230.6	9,792,230.6	535,565.6	471,326.6

3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Урсгал-Ус ХХК нь ТБОНӨХБАУХА тухай хууль, Засгийн газрын 68-р тогтоолоор баталсан босго үнээс давсан 4 төрлийн нийт 129,234.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад холбогдох хууль, дүрмийг мөрдөөгүй байна.

Хүснэгт 13.

Мян.төг

д/д	Барааны нэр	Зардлын дүн /жилээр/	Нийлүүлэгч байгууллагууд
1	Нүүрс	36,777.4	Пүрэвхаан ХХК, Номун Сэлэнгэ ХХК, Анун болор ХХК, Шижир дөл ХХК, Эко партнерс ХХК, Ус боргио ХХК
2	Шатахуун	69,257.0	НИК шатахуун түгээх газар
3	Нормын хувцас	12,200.0	Бизнес линкс ХХК, Бадамлах хүч ХХК, Цогт майнинг ХХК, Эфишинси консалтинг сервис ХХК
4	Цемент	11,000.0	Их этүгэн ХХК
	Нийт дүн	129,234.4	

Өөрөөр хэлбэл тус компани нь орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, гэрээ байгуулж дүгнээгүй, нийлүүлсэн барааг хүлээн авсан комиссын актууд үйлдээгүй байна.

3.2 Үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэргүйгээр акталж иржээ.

Урсгал-Ус ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн ИТХ-ын 2013 оны 104 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, шилжүүлэх, устгах, данснаас хасах ёстой. Гэвч тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг байгууллагын ТУЗ-ийн шийдвэрээр данснаас хасаж иржээ.

Өөрөөр хэлбэл орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг актлахдаа холбогдох баримт материалыг Орон нутгийн өмчийн албанд хүргүүлж аймгийн ИТХ-д оруулж шийдвэр гаргуулах ёстой ч ТУЗ-ийн 03 тоот тогтоолыг үндэслэн данс бүртгэлээс хасжээ. 2015 онд нийт 73 нэр төрлийн 15,502.7 мянган төгрөгийн компьютер техник, тавилга эд хогшлыг акталж, устгасан байна.

Мөн 2011 онд худалдан авсан, тус компанийн дансанд бүртгэлтэй 30,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий өрмийн авто машин хувь хүний эзэмшлээр улсын бүртгэлд бүртгэлтэй байна.

Цаашид орон нутгийн өмчийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу удирдаж, хөрөнгө бэлтгэн нийлүүлэх, данснаас хасахдаа зохих шийдвэрийг үндэслэж байх шаардлагатай байна.

3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна.

Урсгал-Ус ХХК-ийн захирлын 2015 оны 76 тоот тушаалаар эхний хагас жилийн хөрөнгийн тооллогын комиссыг 8 хүний бүрэлдэхүүнтэй, жилийн эцэст 153 тоот тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй томилсон бөгөөд тооллогын комисс нь тогтоосон хугацаанд хөрөнгө, материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулсан байна.

Тооллогоор нийт 4,535,192.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоолсноос 81,382.9 мянган төгрөгийн газар, 9,214,159.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 60,351.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 313,838.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 122,318.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшлын үлдэгдэлтэй байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Урсгал-Ус ХХК-ийн ус хангамжийн болон эрүүл ахуйн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлуудыг улс, орон нутгийн төсөвт суулгаж шийдвэрлэх шаардлагатай байна.
2. Урсгал-Ус ХХК нь зөвхөн санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж байгаа бөгөөд аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, дүгнүүлээгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж, дүгнүүлээгүй байна.
3. Сүхбаатар сум дахь төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоох, бүс тогтоогоогүй объектуудад хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох шаардлагатай байна.
4. ТУЗ-ийн үйл ажиллагаа үр дүн, үр нөлөө муутай байна.
5. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаж ажиллахгүй байна.
6. Урсгал-Ус ХХК нь өөрийн лабораторид усны сорьц шинжилгээ хийж байгаа ч Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNSO900:2005 стандартын дагуу магадлан итгэмжлэгдээгүй, шаардлагатай тоног төхөөрөмж,

мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан зарим үзүүлэлтийг шинжлэн хянаж чадахгүй байна.

7. Урсгал-Ус ХХК нь үр ашигтай ажиллах бүрэн боломжтой байна.
8. Үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж батлуулсан ч төлөвлөсөн үйл ажиллагаагаа явуулаагүй, усны алдагдал тооцоолсноос багассан зэргээс шалтгаалан орлогын төлөвлөгөө 4.7 хувиар тасарсан байна.
9. Урсгал-Ус ХХК нь төсвийг бодитой төлөвлөж батлуулаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаагүй, үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зардал гаргаснаас шалтгаалан төлөвлөсөн зардлыг 2.2 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.
10. Авлага, өглөгийг барагдуулахаар тодорхой ажил зохион байгуулж байгаа ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.
11. Борлуулалтын авлагаас гадна бусад аж ахуйн нэгж өөрийн компанийн ажиллагсдаас авах авлагыг барагдуулах талаар ямар ч ажил хийгдээгүй байна.
12. Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөхгүй байна.
13. Үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ийн шийдвэргүйгээр акталж байна.

Илэрсэн зөрчил /акт, албан шаардлага/

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнд нийт **1,013,820.9** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч **35,787.1 мянган** төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, **583,762.5 мянган** төгрөгийн зөрчилд албан шаардлага, **394,271.3 мянган** төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

Акт:

1. Жавхлант-Эрдэнэ, Орхон импекс, Монхово, Ертөнцийн цамхаг компаниудад дараа тооцоогоор үүссэн авлагыг барагдуулах 35,787.1 мянган төгрөг.

Албан шаардлага:

- 1 Удирдлагын зардлыг 6,137.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,
- 2 Удирдамж, томилолтын үнэмлэх, холбогдох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөл, шийдвэргүйгээр санхүүгийн төлөвлөгөөнд батлагдаагүй гадаад томилолтын зардал гаргасан 21,234.6 мянган төгрөг,
- 3 Хандив олгосон 500.0 мянган төгрөг,
- 4 Хууль эрхийн актын үндэслэлгүйгээр байцаагч Н.Сувд-Эрдэнийн сургалтын төлбөрийг төлсөн 2,100.0 мянган төгрөг,
- 5 НӨАТ-ын тооцоог хаалгүйгээр 24,501.3 мянган төгрөгийн авлага хий тусгасан,
- 6 Өөрийн компанийн ажиллагсадтай үүссэн дараа тооцоог тухай бүр хааж барагдуулаагүй, бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа зарцуулсан ч авлагаар тусган тайлант үеийн зардлыг дутуу тусгасан 58,913.2 мянган төгрөг,
- 7 2015 оны жилийн эцсээр 140,775.7 мянган төгрөгийн авлага, 66,362.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,

- 8 2011 оноос хойш орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3 удаагийн 88,500.0 мянган төгрөгийн ажлыг урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэсэн,
- 9 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөөгүй 129,234.4 мянган төгрөгийн,
- 10 Аймгийн ИТХ-ын зөвшөөрөлгүйгээр 73 нэр төрлийн 15,502.7 мянган төгрөгийн компьютер техник, тавилга эд хогшлыг акталж, устгасан,
- 11 Тус компанид бүртгэлтэй 30,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий өрмийн авто машин нь улсын бүртгэлд хувь хүний эзэмшилд бүртгэлтэй.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасны дагуу Урсгал-Ус ХХК-ийн захиралтай жил бүр гэрээ байгуулж, дүгнэж байх.
2. Урсгал-Ус ХХК-д зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудыг судалж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.
3. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоогүй ус хангамжийн эх үүсвэрүүдэд бүс тогтоолгох саналыг аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих.
4. Урсгал-Ус ХХК-ийн бүтэц зохион байгуулалт оновчтой эсэх асуудлыг мэргэжлийн байгууллагад хандах болон мэргэжлийн комисс ажиллуулан дүгнэлт гаргуулж, зохих арга хэмжээ авах.

Урсгал-Ус ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Стратеги төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мөрдүүлэх, жил бүр гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж байх. Үйл ажиллагааг сайжруулах, өр авлага бууруулах талаар тооцоо судалгаа гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих.
2. ТУЗ-ийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, үр ашигтай болгох, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэн цалин хөлс авдаг нөхцлийг судалж нэвтрүүлэх.
3. Урсгал-Ус ХХК-ийн дүрэм болон аймгийн ИТХ-ын 2013 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж ажиллах.

Урсгал-Ус ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Батболдод:

1. Компанийн стратеги төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, мөрдөж ажиллах.

2. Дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, хяналт шалгалтын мөрөөр ажлын төлөвлөгөө гаргаж гүйцэтгэлийг тайлагнаж байх.
3. 1986 онд тогтоолгосон ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг өнөөгийн хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэхэд судалгаа хийх, бүс тогтоогоогүй барилга, байгууламжуудад хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоолгох арга хэмжээ авах.
4. Компанийн лабораторийг холбогдох стандартын дагуу магадлан итгэмжлэлтэй болгох.
5. Эдийн засгийн үр ашгийн тооцоог бодитой тооцоолсны үндсэн дээр санхүүгийн төлөвлөгөөг батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх.
6. Хугацаандаа төлөгдөөгүй авлагуудыг хуулийн байгууллагад шилжүүлэх, усны авлагыг барагдуулах бусад үр дүнтэй аргуудыг судалж хэрэгжүүлэх.
7. Цэвэр, бохир усны шугам хоолойн тоо хэмжээ, чанар байдлыг нарийвчлан гаргаж хөрөнгийн мэдээллийг тодорхой болгох.
8. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж байх.
9. Компанийн эзэмшилд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг актлах, худалдах, шилжүүлэхдээ холбогдох хууль, журмыг мөрдөх.

Урсгал-Ус ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч А.Алтансүхэд:

1. Санхүүгийн тайлан гаргах болон бусад шаардлагатай үед өр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, бодит бус өглөг, авлагыг бүртгэлд тусгадаг байдлыг таслан зогсоох.
2. Бэлэн мөнгөөр хийгдэж байгаа дараа тайлангийн тооцоог холбогдох заавар, маягтын дагуу гаргаж, шаардлагатай анхан шатны баримтыг бүрдүүлж байх.
3. Бараа материалын хөдөлгөөнийг аккрузл сууриар хөтөлж, тайлант үеийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зардлыг бодитой тайлагнаж байх.

Урсгал-Ус ХХК-иас тайлангийн төсөлд ирүүлсэн саналын тайлбар

Аймгийн Аудитын газрын 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 тоот албан бичгээр “Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлсэн бөгөөд хариуг 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 266 дугаар албан бичгээр ирүүллээ.

Урсгал-Ус ХХК-иас ирүүлсэн санал: Н.Сувд-Эрдэнийн 2,100.0 мянган төгрөгийн сургалтын төлбөр, нэр бүхий ажилтнуудтай үүссэн 54,682.2 мянган төгрөгийн, 2005 оноос өмнө 4 аж ахуйн нэгжтэй үүссэн 35,787.1 мянган төгрөгийн авлагуудыг 2016 ондоо багтаан барагдуулан ажиллах тул актаас хасуулах санал ирүүлжээ.

Аймгийн Аудитын газрын тайлбар:

1. Борлуулалтын байцаагч Н.Сувд-Эрдэнэтэй байгуулсан хүчингүй болсон гэрээг шинэчилж, сургалтын төлбөрийг эргэн төлүүлэх график гаргаж, графикийн дагуу суутгал хийх замаар эргэн төлүүлэх албан шаардлага болгохоор шийдвэрлэв.

2. Компанийн ажилтан, албан хаагчидтай үүссэн 54,682.2 мянган төгрөгийн авлагыг 2016 ондоо багтаан шийдвэрлүүлэхээр хариу ирүүлсэн тул албан шаардлага болгов.
3. Нэр бүхий 4 компанитай холбоотой үүссэн 35,787.1 мянган төгрөгийн авлага нь 2005 оноос өмнө үүссэн 3-13 жилийн насжилттай авлага бөгөөд аймгийн Аудитын газраас акт тавьж нөхөн төлүүлэх нь орон нутгийн өмчийн найдваргүй авлага нэмэгдэх, өмч хөрөнгө үр ашиггүй үрэгдэх эрсдэлийг арилгах тул актыг хэвээр нь үлдээхээр шийдвэрлэв.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Б.ЭРДЭНЭЗУЛ